

Я.Отгонбаяр*МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш,*

МЭДЛЭГ ДАЯАРШИХ ҮЙЛ ЯВЦЫН ӨӨРЧЛӨЛТ БА ДЭЭД БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА

Abstract: *Globalization constitutes a new trend in the world economy, politics, culture and education. Highly educated staff determines competitor value of a country based on knowledge. Therefore educational institutions of all levels bear responsibility to preparing highly educated staff. In fact we are not ready to world globalization. Thus present level of high education is issued upon globalization trends.*

Key words: *globalization, high education, knowledge, economy, politics, culture.*

Удиртгал

Дээд боловсрол нь боловсролын тогтолцооны дээд шат бөгөөд түүний мөн чанар бол суралцагчдад мэдлэг олгоод зогсохгүй мэдлэгийг бие дааж олж эзэмших, түүнийгээ амьдрал практикт хэрэглэх чадвар дадал төлөвшүүлэхийн хамт тэдэнд судалгаа шинжилгээний арга барил эзэмшүүлэх, оюутныг мэргэжилтэн бие хүн болгон төлөвшүүлэх явдал юм. Энэ утгаараа дээд боловсрол нь нийгмийн баялагийг өсгөн баяжуулах бүтээлч чадавх бүхий мэргэжилтэн бэлтгэн төлөвшүүлдэг учир нийгмийн хөгжилд ихээхэн ач холбогдолтой.

Өнөөдөр дээд боловсролын салбарт макро түвшний буюу сургалтын кредит цагийн тогтолцоо, сургалтанд технологийн дэвшлийг өргөн ашиглах, е-сургалт, хамтарсан хөтөлбөр, сургалтын төлбөр, магадлан итгэмжлэл зэрэг “хэлбэр”-ийн шинэчлэлүүд хийгдэж байгаа хэдий ч сургалтын дотоод агуулга, чанар, хүний нөөцийн бодлого буюу багшлах боловсон хүчний шинэчлэлийн асуудлууд төдийлөн эрчимтэй шинэчлэгдэж чадахгүй байна. *Тийм учраас өнөөдөр даяаршлын эрин үед монголын дээд боловсролын салбарын хөгжил, даяаршилтай хэрхэн хөл нийлж байна вэ гэдэг асуудлыг энэхүү өгүүлэлдээ бага боловч хөндөхийг зорилго.*

Даяаршлын орчин дахь монголын дээд боловсрол

Монголын өнөөгийн нийгэм, улс төрийн амьдрал, хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлд глобальчлал, даяарчлал, даяаршил, дэлхийчлэл хэмээх нэр томъёо, ойлголт өргөн дэлгэрч монгол улсыг дэлхий дахиныг хамарсан энэ үйл явцад идэвхтэй оролцох тухай шинжилгээ, судалгаа, төрийн бодлогын түвшинд их ярьж тайлбарлах боллоо.

Мэдлэгт суурилсан эдийн засгийг шинэ эдийн засаг гэх нь бий. Интернетийн хэрэглээ өргөжиж, компьютер, теле харилцааны технологи хүмүүсийн өдөр тутмын хэрэглээ болсноор дэлхийн улс орнуудын эдийн засаг хорь гучин жилийн өмнөхөөс тэс өөр болж хамтын ажиллагаа бүх талаар өргөжиж эхэлсэн. Энэ их өөрчлөлтийн давалгааг бид даяаршил хэмээн нэрийдэж буй билээ. Эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах үндсэн арга зам бол хүн амын боловсролын түвшинг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчний мэдлэг чадварыг шинэ нөхцөлд тохируулан улам бүр хөгжүүлэх явдал бөгөөд энэ үүргийг бүх шатны боловсролын байгууллага, түүний дотор их дээд боловсролын байгууллага биелүүлэх шаардлагатай.

Өнөөдөр дэлхий даяар хүчтэй өрнөж буй даяаршил нь нийгмийн бүх салбарт хүчтэй нэвтрэн орж ирж байна. Өөрөөр хэлбэл даяаршил нь эдийн засаг, улс төр, гэр бүлийн харилцаа, боловсрол, соёл урлаг зэрэг нийгмийн бүхий л социаль институтийг хамарсан их өөрчлөлтийг эхлүүлсэн. Өнөөдөр боловсрол ч мөн адил даяаршиж байна. Боловсролын хөгжлийн асуудал нэг улс, нэг үндэстний хэмжээнээс хальж, түүний хөгжлийн хүчин зүйлүүд нь нэг хэсэг улс, бүхэл бүтэн тив, бүс нутаг, цаашлаад дэлхийн хэмжээний асуудлаас хамааралтай байх болжээ. Энэ тохиолдолд бид дэлхийн жишигт хүрсэн мэргэжилтэн бэлтгэх, боловсролын гадаад зах зээл дээр хамтран ажиллах, техник технологийн дэвшлийг нутагшуулах зэргээр боловсролын даяаршилтай хөл нийлэх, зэрэгцэн хөгжих зайлшгүй шаардлагыг даяаршил нөхцөлдүүлж байна. Гэтэл бид хэр зэрэг бэлэн байна вэ гэдэг нь асуудлын гол зангилаа болж байна.

Дэлхийн улс орнууд мэдлэгт суурилсан эдийн засгийг бүтээж, шинжлэх ухааны багтаамж ихтэй өндөр технологит суурилсан үйлдвэрлэлийн хүрээ өргөжиж оюуны капитал нь улс орны

өрсөлдөх чадварын гол үүсвэр болж, боловсролын агуулга тасралтгүй, уян хатан шинжтэй болж, хүн насан туршдаа, шаардлагатай боловсролоо хүссэн цагтаа, зохимжтой хэлбэрээр нь эзэмших боломжийг өргөтгөх чиглэлээр боловсролын бодлогыг боловсруулж сургуулийн тогтолцооноос эхлээд нийт нийгмийн хэмжээгээр төлөвлөн хэрэгжүүлж байна. Бид ч энэ туршлагаас суралцаж байна.

Дээд боловсрол эзэмших шинэ хэлбэрүүд тухайлбал e- сургалт, хамтарсан зэрэг олгох e-тестийн үйлчилгээ зэрэг нь боловсролын даяаршлыг улам бүр эрчимжүүлж байна.

Шинэ зууны дэлхийн боловсролын хөгжлийн чиг хандлагыг мэдэрч, монгол улс дотооддоо хүлээгдэж байгаа өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэхэд боловсролын салбар дахь шинжлэх ухааны судалгаа шинжилгээ нэн чухал байна. Ялангуяа боловсролын социологи энэ үүргийг хэрэгжүүлэх боломжтой бөгөөд дээд боловсрол түүний чанар, үр өгөөж, багшлах боловсон хүчний нийгмийн асуудал, мэдлэг боловсролоо дээшлүүлэх боломж зэрэг олон тулгамдсан асуудал нь нийгмийн үзэгдэл, үйл явцын шалтгааныг нийгмийн харилцаа түүний холбоо хамааралд нь авч үздэг социологийн шинжлэх ухааны судлах зүйлээс ангид байх боломжгүй юм.

Даяаршлын нийгэм нь нийгмийн гишүүдэд интернетийн өргөн хэрэглээ, хоёроос доошгүй гадаад хэл эзэмших, харилцааны соёл, мэргэжлийн ёс зүй, багаар хамтарч ажиллах ур чадвар зэрэг өндөр шаардлагыг тавьж байгаа бөгөөд эдгээр чадавхыг дээд боловсролоор дамжуулан олгох ёстой.

Өөрөөр хэлбэл өнөөдөр дээд боловсролын байгууллага нь мэдлэгийг даяаршуулах гол социаль институт болж байна. Гэтэл дээд боловсролын байгууллага орчин үеийн нийгмийн шинэ эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэргэжилтэн бэлтгэх үүргээ хангалтгүй биелүүлж байгаа талаар судаачид шүүмжлэн хэлэлцсээр байна.

Нэгэн судалгааны мэдээлэлээс иш татвал: ЮНЕСКО, БСШУ-ны яамны Хяналт, үнэлгээ, мониторингийн газар хамтран 2009-2010 онд 40 гаруй хувийн болон улсын их дээд сургуулийн 400 орчим багш нарын дунд судалгаа¹¹⁰ явуулсан бөгөөд тус судалгааны ...Судалгааны ажил хийхэд тохиолддог бэрхшээлүүдийг дурьдана уу гэсэн асуултанд дийлэнх олонх буюу 51.9 хувь нь сургалтын цагт их дарагддаг, 14 хувь нь сургуулийн бусад захиргааны ажилд цаг зардаг, бусад нь судалгааны арга зүй хангалттай эзэмшээгүй, мэргэжлийн ном материал олдоц муутай, гадаад хэл, интернетийн мэдлэг хангалтгүй гэсэн шалтгаануудыг дурьджээ. Их дээд сургууль нь сургалтын зэрэгцээ эрдэм шинжилгээ, судалгааны орчин байх нь тэдний эдийн засгийн болон мэдлэгийн илүү өргөн эх үүсвэрийн баталгаа болох ёстой. Гэтэл бодит байдал дээр их дээд сургуулиуд багш нарыг сургалтын цаг, захиргааны ажлаар хэт их “дарах” хандлага түгээмэл байсаар байгааг харж болохоор байна.

Дээд боловсролын өнөөгийн байдалд зарим талаар шүүмжлэлтэй хандвал:

- Дээд боловсролын сургалтын чанар, нийлүүлэлт нь суралцагч, ажил олгогч, олон нийтийн эрэлтэнд нийцэхгүй байна.
- Мэдлэгийн хүрээг тэлэх, технологийн хөгжлийг хөтлөх үүрэгтэй их сургуулийн систем институтчилагдах үйл явц удаашралтай байна.
- Дээд боловсролын эрх зүйн орчин, санхүүжилтын тогтолцоо тодорхойгүй байна
- Дээд боловсролын сургалт, судалгаа, зах зээлийн эрэлт, хэрэгцээ, үндэсний хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдахгүй байна.
- Дээд боловсролын байгууллагын удирдлагын арга барил, менежментийн ур чадвар дутагдалтай, багш нарын цалин бага, хөдөлмөрийн үнэлэмж хангалтгүй байна.

Жишээ нь: түрээсийн хэдэн өрөөнд сургалт явуулах, оюутны төлбөрөөр дөнгөн данган санхүүжиж, цалингаас хэтэрч хөрөнгө оруулалт хийх боломжгүй, оюутанд шаардлагатай мэдлэг чадварыг эзэмшүүлэх тал дээр учир дутагдалтай ажиллаж байгаа олон жишээ байна. Ийм байдал нь бидний өмнөө тавьж буй дэлхийн жишигт хүрсэн мэргэжилтэн бэлтгэх зорилгоо биелүүлж чадахгүй, даяаршлаас хоцроход хүргэнэ.

Дээд боловсролын байгууллагын өнөөдрийн бодит байдлын талаарх зарим нэгэн тоог авч үзвэл:

- 2010-2011 оны хичээлийн жилд төрийн болон төрийн бус өмчийн 113 сургуульд 170126 оюутан суралцаж байгаа бөгөөд өнгөрсөн онд 34211 оюутан төгссөний 40.6 хувь нь буюу 13906 хүн ажлын байраар хангагдсан гэсэн статистикийн тоо баримт байна.

¹¹⁰ ЮНЕСКО, БСШУЯ-ны Хяналт, үнэлгээ, мониторингийн газрын хамтарсан судалгааны анхдагч мэдээлэлээс иш татав. УБ.,2010

Үүний цаана үлдэх 59.4 хувь нь ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж байна уу гэдэг асуулт гарч ирж байна.¹¹¹

- Хөдөлмөрийн зах зээл дээр инженер техник, технологи, хөдөө аж ахуйн чиглэлийн мэргэжилтэн шаардлагатай байхад бэлтгэгдэж буй мэргэжилтний дийлэнх нь буюу 46 хувь нь нийгмийн ухаанаар суралцаж, 17 хувь нь техник технологийн чиглэлээр суралцаж байна. Эндээс дээд боловсролын байгууллага зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан мэргэжилтэн бэлтгэх тал дээр дутагдалтай байгааг харж болохоор байна.
- Төрөөс дээд боловсролын байгууллагад үзүүлэх санхүүгийн дэмжлэг, хөрөнгө оруулалт хангалтгүй байгаа учраас сургалтын төлбөрөөр үндсэн үйл ажиллагаагаа явуулж сургалтын орчинг сайжруулах, техник, хэрэгсэл, номын сангийн фондыг сайжруулах боломжгүйд хүргэж байна.
- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй дээд боловсролын сургалтын байгууллагын дотор 100 аас доош оюутантай сургууль 17, 100-300 хүртэлх оюутантай сургууль 26, 300-500 хүртэлх оюутантай сургууль 20, 500-1000 хүртэлх оюутантай сургууль 26, 1000 аас дээш оюутантай сургууль 24 байна. Ийнхүү олон жижиг сургууль байгаа нь хүн, хүч, эдийн засгийн нөөц тарамдаж сургалтын чанарт муугаар нөлөөлөхийн зэрэгцээ боловсролын байгууллагын нэр хүндийг олон нийтэд унагаж байна.
- Дээд боловсролын байгууллагад өнөөдөр 7183¹¹² багш ажиллаж байгаа бөгөөд тэдний 8.3 нь л дөнгөж өнгөрсөн онд гадаадад мэргэжил дээшлүүлсэн байна. 2011 онд дотоод гадаадад багш нарын мэргэжлийг дээшлүүлэхэд зориулан 27.5 сая төгрөгийг төсөвлөсөн нь хангалттай үзүүлэлт болж чадахгүй байна. Эдгээр үзүүлэлтүүд нь биднийг даяаршлаас ихэд хоцорч байгааг илтгэнэ.

Өнөөдөр нийгмийн бүхий л хүрээг хамран явагдаж буй даяаршлаас хамгийн их хоцрогдож байгаа, шинэчлэлийн үйл явц нь удаашралтай байгаа нь дээд боловсролын салбар гэж бид шүүмлэлтэй хандаж байна. Судлаач Ж.Даваа¹¹³ их дээд сургууль ямар байх талаар ...их дээд сургууль нь насанд хүрсэн хүмүүстэй ажилладаг тул глобал орчны шаардлагыг харгалзан тэдний бие хүний төлөвшилд нь илүү их үүрэг хүлээх ёстой ... хэмээн тэмдэглэсэн байдаг. Үнэхээр өнөөдрийн дээд боловсролын агуулга хэт шинжлэх ухаанч хандлагыг баримтлаж суралцагчдын төлөвшил, ёс зүйд хандсан агуулга төдийлөн байхгүй байгааг ч бид бас эргэн харах ёстой. Дээд боловсролын талаарх дэлхий дахины бага хурлаас гаргасан албан ёсны мэдэгдэлд¹¹⁴...дээд боловсролын байгууллагууд нь өөрийн үндсэн үүргээрээ (судалгаа, шинжилгээ, сургалт, нийгмийн үйлчилгээ) байгууллагын бие даасан байдал болон сургалтын эрх чөлөөний агуулгын хүрээнд мэргэжлийн хоорондын уялдаанд анхаарлаа хандуулж, ёс зүйтэй, шүүмжлэлт сэтгэхүй бүхий иргэнийг дэмжих байдлаа нэмэгдүүлэх ёстой... гэж тунхагласан.

Ийнхүү дээд боловсролын салбарт зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай олон асуудал хуримтлагдсаар, цаг хугацаа, дэлхийн хөгжил урагшласаар байна. Эдгээрийг оновчтой, хурдтай, зөв шийдвэрлэх нь манай дээд боловсролын салбарын цаашдын хөгжилд тэр хэмжээгээрээ эерэг үр дүнг авчрах болно.

Дүгнэлт

- Зах зээлийн өрсөлдөөнт нөхцөл, даяаршлын орчинд монгол хүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үндсэн арга зам нь тэдэнд чанартай боловсролыг эзэмшүүлэх явдал бөгөөд иргэдэд чанартай боловсролыг эзэмшүүлэхийн тулд сургалтын агуулга, технологи, хөтөлбөрийг шинэчлэх, мэргэжилтний зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг харгалзах, багшлах боловсон хүчнийг хөгжүүлэх, дэмжих замаар дээд боловсролын шинэчлэлийг эрчимжүүлэх.
- Дээд боловсролын байгууллагуудыг бүтцийн зохистой тогтолцоонд оруулж хүн хүч, эдийн засгийн нөөц бололцоог цөөн тооны сургуулиуд болон хөтөлбөрт төвлөрүүлэх замаар дэлхийн стандартад хүргэж, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай, олон улсын жишигт нийцсэн их дээд сургуулиудыг бий болгосны үндсэн дээр улс орны хөгжилд шаардлагатай хүний нөөц, мэдлэг, технологийг тасралтгүй нийлүүлэх боломжтой болно.

¹¹¹ Батсайхан.Х “Дээд боловсрол эрэлт, хэрэгцээ” нийтлэл., <http://www.mecs.gov.mn/> УБ.2011

¹¹² Дээд боловсролын шинэчлэлийн зураглал \ROADMAP 2010-2021\.,<http://www.mecs.gov.mn/article.-439-448 mv>.

¹¹³ Даваа. Ж Дээд сургуулийн сургалтын технологи.УБ.,2008 х-25

¹¹⁴ Дээд боловсролын талаарх дэлхий дахины бага хурлын албан ёсны мэдэгдэл. ЮНЕСКО, Парис. \2009-07-5-8\ орч. УБ.,2010

- Даяаршил гэдэг нь өрсөлдөөн гэхээсээ илүү хамтарч ажиллах боломж нөхцөл юм. Тийм учраас их дээд сургуулиудын хамтын ажиллагааг гадаад болон дотоодод сургалт, судалгааны ажлын хүрээнд өргөжүүлэх нь тэдэнд хүчээ нэгтгэж далайцтай шинэчлэл хийх боломжийг олгоно.

Эцэст нь дэлхий даяар өрнөж байгаа шинэ амьдралын хэв маягт бидний монголчууд нэгдэн орж, хөл нийлүүлэн алхах нь бидний ирээдүйн хөгжлийн зам мөн учраас ялангуяа боловсролын салбарыг хэрхэн дэлхийн жишигт хүргэн өөрчлөн шинэчлэх вэ гэсэн улмаар хэрхэн инноваци бий болгох вэ асуудлыг нэгэн өгүүлэлийн хүрээнд авч үзээд орхих нь дэндүү хангалтгүй тул цааш цаашдаа судалгаа шинжилгээний ажлыг илүү эрчимжүүлэн хийх шаардлагатай гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Ном зүй :

1. ЮНЕСКО, БСШУ-ны яамны хамтарсан судалгааны анхдагч мэдээлэл. УБ.,2010
2. Батсайхан.Х “Дээд боловсрол эрэлт, хэрэгцээ” нийтлэл., <http://www.mecs.gov.mn>\ УБ.2011
3. Дээд боловсролын шинэчлэлийн зураглал \ROADMAP 2010-2021\.,<http://www.mecs.gov.mn>,\article.-439-448 mv.
4. Даваа. Ж Дээд сургуулийн сургалтын технологи.УБ.,2008
5. Дээд боловсролын талаарх дэлхий дахины бага хурлын албан ёсны мэдэгдэл. ЮНЕСКО, Парис. \2009-07-5-8\ орч. УБ.,2010